



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 07 сарын 23 өдөр

Дугаар А/478

Хөрөнгө гаргах тухай

Ховд

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Монгол улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.42 дахь заалт, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.2 дахь заалтыг хэрэгжүүлэх, үндэсний өв соёлоо дэлхийд сурталчлах, хамгийн олон хөөмийчтэйгээр Геннисийн номонд бүртгүүлэх ажлыг зохион байгуулах зардалд 4000000 төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх үйл ажиллагаанд шаардагдах 4000000 төгрөг /Дөрвөн сая/-ийг Хөшөөт хөгжил сангийн төсөл, арга хэмжээний 2018 оны төсвийн тодотголоор батлагдсан 4.6 дахь заалтад тусгагдсан зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Б.Даваадорж/-д үүрэг болгосугай.


ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



Zax A/478 Ch
02 02358

Аймгийн Засаг даргын 2019 оны 07 дугаар
сарын 23- ны өдрийн А/478 дугаар захирамжийн
хавсралт



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Үйл ажиллагааны зардал	Тоо ширхэг	Нэгж үнэ /төг/ Өглөө, өдөр, оройн хоол	Нийт /төг/
1	Чандмань сумаас ирж зураг авалтад оролцох хүүхдүүд, багш гарын хоолны зардал	13 2 өдөр	20000	520000
2	Чандмань-Ховд- Чандмань ирж буцах болон хот доторх, орчмын зураг авалтын унааны зардал	550 км		480000
3	Дэлхийн хөөмийн холбооны холбооны төлөөлөгчийн ажлын урамшуулал	1хүн 3 өдөр	100000	300000
4	Албан тоот, email –н орчуулгын зардал	2,5 хуудас	100000	100000
5	Ховд –УБ хот онгоцны зардал	1 хүн	400000	400000
6	Гэрээний дагуу зөвлөхийн урамшуулал	1 хүн	1000000	1000000
	Гиннесийн рекордын Бээжин дэх салбарт очиж ажилласан зардал	1 хүн	1200000	1200000
	Нийт			4000000

-oOo-